



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Төсвийн төлөвлөлтийг хөгжлийн бодлого,
төлөвлөлттэй уялдуулах тухай

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 7.1, 11.1.1 дэх заалт, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэсний хорооны ажиллах журам”-ын 2.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.2025 оны төсвийн төлөвлөлтийг хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулан боловсруулах, төлөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төсвийн төсөлд тусган боловсруулах, зураг-төсөв батлагдаагүй, холбогдох тооцоо, судалгаа хийгээгүй арга хэмжээг бодлогын баримт бичигт тусгахгүй байх талаар төсвийн ерөнхийлөн захирагч нарт зөвлөмж хүргүүлэхийг Авлигатай тэмцэх газрын дарга Ч.Дашдаваад зөвлөж, хэрэгжилтийн явц, үр дүнг танилцуулахыг Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх газрын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтсийн дарга бөгөөд Авлигатай тэмцэх газрын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэсний хорооны орлогч дарга М.Даваатогтоход үүрэг болгосугай.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үндэсний хорооны орлогч дарга нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН





ЯАМДЫН ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА НАРТ
ТАНАА

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2024.06.06 № 08/9956
танай _____-ны № _____-т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 7.1 дэх зорилт (Төсвийн төлөвлөлтийн тогтолцоог урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулж, тэгш хүртээмжтэй, нээлттэй, олон нийтийн оролцоог хангах замаар бэхжүүлнэ), Засгийн газрын 2024 оны 19 дүгээр тогтоолоор байгуулагдсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэсний хорооны 2024 оны 02 дугаар тогтоолыг үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. 2025 оны төсвийн төлөвлөлтийг урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлттэй уялдуулах,
2. “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ыг мөрдөн ажиллаж Үндэсний хорооны тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллахыг зөвлөж байна.

Хавсралт: Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэсний хорооны 2024 оны 02 дугаар тогтоол-1 хуудас.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХЭРЭГИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР М.ДАВААТОГТОХ



142403009769